## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

/2021 оны эхний хагас жилийн байдлаар/

Багахангай дүүрэг

2021.06.18

| № | Агуулга | Нийт заалтын тоо | Бүрэн хэрэгжсэн | Хэрэгжих шатандаа | Тасарсан | Хэрэгжилт Тооцох болоогүй | 100 | 70 | 30 | 0 | Үнэлгээ /хувь/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын хууль | 27 | 6 | 21 | - | - | 6 | 20 | - | - | 73.5 |
| 2 | Улсын их хурлын тогтоол | 1 | - | 1 | - | 1 | - | 1 | - | - | 70 |
| 3 | Ерөнхийлөгчийн зарлиг | 2 | - | 2 | - | - | - | 1 | 1 | - | 50 |
| 4 | Засгийн газрын тогтоол | 9 | 1 | 8 | - | 1 | 1 | 7 | | - | 68.9 |
| Нийт | | 39 | 7 | 33 | - | 2 | 7 | 29 | 1 | | 65.8 |

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ЭРДЭНЭТУЯА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Х.ЦЭЦЭГСҮРЭН

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт**
**/Эхний хагас жилийн байдлаар/**

2021.06.18 Багахангай дүүрэг

| № | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ, (хүчин гүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| Монгол Улсын хууль | | | | | |
| 1. | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай<br>2011-06-16<br>Дугаар 2011.06.16 | 7.1.1.Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | ЗДТГ-ын дүрэм, эрхэм зорилгыг bagakhangai.ub.gov.mn сайтын "Тамгын газар" цэсний "Дүрэм журам" дэд цэсэнд, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/121 дүгээр захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2020 оны А/44 дүгээр захирамжаар батлагдсан "Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалтыг батлах тухай" бүтэц орон тооны захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/09 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалт, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" тушаалыг "Бүтэц, орон тоо" дэд цэсэнд байршуулав. Дээрх мэдээллийг байгууллагын "Мэдээллийн ил тод байдал" самбарт тогтмол байршуулж байна. Дүүргийн Цагдаагийн хэлтэс хэлтсийн албан ёсны bagakhangai.police.gov.mn сайт, "Багахангай Цагдаагийн хэлтэс" фэсбүүк цахим хуудсанд 280 удаа, Онцгой байдлын хэлтэс "Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс" веб сайтад 1 удаа, Дотоод аудитын алба www.shilendans.gov.mn, сайт болон "Багахангай Дотоод аудитын алба"-ны фэйсбүүк хуудсанд 57 удаа тус тус байршуулаад байна. Нийгмийн салбарын 8 байгууллага хагас жилийн байдлаар 1000 гаруй мэдээ мэдээллийг өөрсдийн фэйсбүүк хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2. | | 7.1.2.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний нэр, албан тушаал, утасны дугаар, өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг bagakhangai.ub.gov.mn сайтын "Төрийн үйлчилгээ" цэсэнд болон "Мэдээллийн ил тод байдал" самбарт байрлуулан тухай бүр шинэчилж байна.<br>Дүүргийн 22 байгууллага өргөдөл гомдол хүлээн авах ажилтны мэдээлэл, иргэдийг хүлээн авч уулзах хуваарийг мэдээллийн самбар болон цахим хаягуудад байршуулан ажиллаж байна. | 100% | |
| 3. | | 7.1.3.Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | ЗДТГ төрийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний нэр төрөл, бүрдүүлэх материалын жагсаалтыг bagakhangai.ub.gov.mn сайтын "Төрийн үйлчилгээ" цэсэнд байршуулан иргэдэд хүргэж байна. ЭМТ эмнэлгийн тусламж, үйлчилгээ, Боловсролын салбарын байгууллагууд элсэлтийн талаарх мэдээлэл, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, ХХҮХ төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт, төсөл, хөтөлбөрүүдийн талаарх гарын авлага, холбогдох материалыг боловсруулан мэдээллийн самбарт болон өөрсдийн цахим хаягаар дамжуулан иргэдэд хүргэж байна. | 70% | |
| 4. | | 7.1.4.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын жагсаалтыг гарган bagakhangai.ub.gov.mn сайтын "Ил тод байдал", "Хууль эрх зүй" цэсэнд байршуулан иргэдэд хүргэж байна.<br>Нийгмийн даатгалын хэлтэс нийгмийн даатгалын хуулийг сурталчилсан нийт 44 шторк, ХХҮХ байгууллагын хэмжээнд мөрдөгдөх 25 хууль, 4 дүрэм, журмыг www.bagakhangai.hudulmur-halamj.gov.mn веб хуудсанд, 5 хууль, 3 дүрэм, журам, 5 тогтоолыг хэлтсийн мэдээллийн самбарт байршуулсан.<br>Мөн шинээр гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг өөрсдийн цахимаар тухай бүр иргэдэд хүргэж байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5. | | 7.1.5.Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; | Багахангай дүүргийн Bagakhangai.ub.gov.mn вэб сайтын дүрэм, журмын төсөл цэсэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг байршуулав. | 70% | - |
| 6. | | 7.1.6.Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | Коронавируст цар тахлын улмаас танхимын сургалт, хурал цуглаан явуулахыг хязгаарласан бөгөөд Microsoft team, zoom, google meet программыг ашиглан дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулж байна.<br>E-mongolia төрийн мэдээллийн нэгдсэн системээс Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа, НД-ын цахим дэвтэр, тэтгэвэр тэтгэмж болон төрийн байгууллагын бүх үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон.<br>Хөдөлмөр эрхлэлтийн бүх үйлчилгээг иргэдийн гар утсанд мессеж хэлбэрээр 2018 оноос эхлэн хүргэн ажиллаж байна.<br>Халамжийн нэгдсэн e-halamj систем нэвтэрсэнтэй холбогдуулан 70491180 дугаарын утсыг ажиллуулж иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч тухай бүр нь шийдвэрлэн ажиллаж байна.<br>Короновируст халдвар /covid-19/ цар тахлын улмаас хичээл сургалтын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнтэй холбогдуулан<br>ЕБС-ийн хүүхдэд зориулсан 32 видео хичээл, 4 контент, СӨБ-ын хүүхдэд зориулсан 26 төрлийн цахим хичээлийг бэлтгэн эцэг эх асран хамгаалагч хүүхдүүдэд хүргэв. Мөн соёл, спортын чиглэлээр цахимаар тэмцээн уралдааныг зохион байгуулж байна.<br>Иргэд олон нийтэд болзошгүй гамшиг, ослоос | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг цахимаар буюу хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан 112 удаа зохион байгуулж, урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргүүлэх үүднээс малчин 238 өрхөд 7 удаа мессэж багцаар сэрэмжлүүлэг мэдээг хүргүүлсэн байна. | | |
| 7. | | 7.1.7.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; | Дүүргийн хэмжээнд "Ахмадын хороо", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо" болон "Улаан загалмай хороо" төрийн бус байгууллага нь Төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг гүйцэтгэн хэрэгжүүлж байна. Ахмадын хороо Засаг даргатай хамтран ажиллах гэрээг 20 арга хэмжээтэй, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо 2021 онд хэрэгжүүлэх 19 заалттай, "Улаан загалмай хороо" хамтран ажиллах гэрээг тус тус боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Ахмадын хороонд 40.0 сая төгрөгийн санхжүүжилт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонд 3.6 сая төгрөгийн урамшуулал, УЗХ-д жилд 19.965,600 төгрөгийн санхүүжилтийг тус тус дүүргийн төсвөөс олгохоор болсон байна.<br>Дээрх төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулан ажиллав. | 70% | |
| 8. | | 7.1.8.Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Дүүргийн Засаг даргын 2021 оны А/46 дугаар захирамжаар Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрээс гадна байрлах Худалдааны газар, түүний үйлчилгээ MNS5021:1-2019 стандартын шаардлага хангасан 1-р хорооны иргэнд 3 жилийн хугацаатай тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгов. Тус зөвшөөрлийн мэдээллийг www.Bagakhangai.ub.gov.mn сайтад байршуулсан. | 100% | |
| 9. | | 7.1.9.Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон | Тайлангийн хугацаанд Тайваний Хүүхэд гэр бүлийг дэмжих санд 40 өрхийн 117, Кристина нобелийн | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх; | хүүхдийн санд 4 өрхийн 4, нийт 44 өрхийн 121 хүүхдийг хамруулж 2.9 сая төгрөгийн тусламж дэмжлэг олгосон байна.<br>ӨМӨЗО-ны "Улаан загалмай" байгууллагын дэмжлэгээр 200 өрхөд 5.9 сая төгрөг, БНХАУ-ын "Улаан загалмай байгууллагаас 20 өрхөд 1.2 сая төгрөгийн хүнсний тусламж, 250.0 мянган төгрөгийн 1000 ш амны хаалт хандивлав. МУЗН-ээс эрүүл мэндийн онцгой үед ажиллах сайн дурын 15 идэвхтэнд зориулсан 2.4 сая төгрөгийн иж бүрэн үүргэвч цүнх, 1.6 сая төгрөгийн 10 боодол Финлянд хувцас олгов.<br>Коронавируст халдвар /Ковид 19/-ын цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд БНСУ-ын "Global share", "Энх Хүслэн хайрын гар" төрийн бус байгууллагатай хамтран 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 43 ААНБ-ын ажилтан албан хаагчдад 100.000 ширхэг амны хаалтыг олгов.<br><br>Дүүрэгт 2021 оны эхний хагас жилийн байдлаар олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас нийт 14.2 сая төгрөгийн тусламж дэмжлэг олгогдоод байна. Мэдээллийг тухай бүр дүүргийн вэб сайт, Багахангай хэвлэл мэдээлэл facebook хуудсаар мэдээлж ажиллав. | | |
| 10. | | 8.1.1.Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах; | Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллах хүрээнд Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020 оны А/121 дүгээр захирамжаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу албан хаагчдыг томилон ажиллуулж байгаа ба бүтэц орон тооноос илүү томилсон албан хаагч байхгүй байна.<br>2021 оны эхний хагас жилийн байдлаар тус газарт 8 ажлын байрны сул орон тоо байгаа бөгөөд дээрх ажлын байранд тусгай шалгалт зохион байгуулах захиалгыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн, одоогоор тусгай шалгалт зохион байгуулах хугацаа тодорхойгүй байна. Төрийн албаны ерөнхий шалгалтын хуваарь гарч 06 дугаар | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | сарын 14-ний өдрөөс эхлэн зохион байгуулагдаж эхлээд байна.<br>Багхангай дүүргээс төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр 44 иргэн бүртгүүлээд байгаа ба тус Тамгын газраас шалгалт өгөх 4 албан хаагчид хууль тогтоомж, монгол хэл, мэдээлэл технологи, түүх, эдийн засаг, дүн шинжилгээ хийх чиглэлээр өдөр бүр 2 цагийн давтлага өгч, тест бөглүүлэн шалгалтад бэлтгүүлэн ажилласан. Байгууллагад гарсан сул ажлын байрны талаарх мэдээллийг bagakhangai.ub.gov.mn сайтын "Хүний нөөцийн ил тод байдал" цэсэнд байршуулан иргэдэд хүргэж байна. | | |
| 11. | | 8.1.3.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Байгууллагын "Төрийн албан хаагчийн сургалт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны төлөвлөгөөг 4 бүлэг, 12 арга хэмжээтэйгээр боловсруулж батлуулан байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хавсарган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Төрийн албан хаагчийг сургаж хөгжүүлэх ажлын хүрээнд нийт 20 төрлийн сургалтад давхардсан тоогоор 145 албан хаагчийг цахимаар хамрууллав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны төлөвлөгөө, эхний хагас жилийн биелэлтийг bagakhangai.ub.gov.mn сайтын Ил тод байдал цэсний "Байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээ" дэд цэсэнд байршууллаа. | 70% | |
| 12. | | 8.1.4.Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах боломжийг бүрдүүлэн удирдлагыг мэдээллээр хангаж, ажлын байрны сул орон тоо гарсан тухай бүр ажлын байрны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн, сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Байгууллагад гарсан сул ажлын байрны талаарх мэдээллийг bagakhangai.ub.gov.mn сайтын "Хүний нөөцийн ил тод байдал" цэсэнд байршуулан иргэдэд хүргэж байна. Мөн албан хаагчдыг чадавхжуулахад анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран зохион | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байгуулсан 20 төрлийн сургалтад давхардсан тоогоор 145 албан хаагчийг цахимаар хамруулан мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх, нэгнийгээ орлох чадвартай болгоход анхааран ажиллаж байна. | | |
| 13. | | 8.1.5.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | ЗДТГ-ын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад арга зүйн заавар зөвлөмжийг өгч ажиллав. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалын дагуу нэгжийн менежер-4, төрийн захиргааны 20, төрийн тусгай 3, төрийн үйлчилгээний-15, гэрээт-8 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө, 5 албан хаагч үр дүнгийн гэрээг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав. Албан хаагчдын 2021 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор авч, дүгнэхээр бэлтгэл хангаад байна. Байгууллагын үнэлгээний багийг даргын тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулав. Засгийн газрын 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 100 дугаар тушаалыг цахим хуудаст байршуулан ажиллав. | 70% | |
| 14. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/<br><br>2015-07-08<br><br>Дугаар 2015.09.01 | 9.2.2.Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх урт болон богино хугацааны хөтөлбөр батлах; (9.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үүргийг хэрэгжүүлнэ:) | Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2020-2023 он хүртэл урт хугацааны хөтөлбөрийг ГХУСАЗСЗ-тэй хамтран батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. | 100% | |
| 15. | | 9.2.4.Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах шийдвэр гаргах, төлбөрийн хувь хэмжээг тогтоох. (9.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад аймаг, нийслэл, сум, | Улсын чанартай А0101 автозамын хяналтын цэгт тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулахаар 2022 оны төсөвт төсөлд саналаа оруулахаар тооцоо судалгааг гарган дээд шатны байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна. | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үүргийг хэрэгжүүлнэ:) | | | |
| 16. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/<br><br>2016-12-22<br><br>Дугаар 2017.02.01 | 18.1.1.Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | "Эрүүл орчин–Иргэдийн сайн сайхан" III арга хэмжээний төлөвлөгөөг 4 бүлэг 20 заалттайгаар боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны А/06 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2021 оны А/28 дугаар захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.<br>ЗДТГ, Цагдаагийн хэлтэс, ГБХЗХХ, Хороодын ажлын албанаас хамтран 2021 оны 03 сарын 30, 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Алтгана, Үнэгтэй, Бор үзүүр, Цайдам, Замчин Нуурын гэр хорооллын орчимд хяналт шалгалт зохион байгууллаа. Байнга архи согтууруулах ундаа хэрэглэдэг, архидалт зохион байгуулдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 16 айл өрхөөр орж нөхцөл байдалтай танилцав. Шалгалтын явцад архи согтууруулах ундаа хэрэглэсэн 1 иргэнд анхааруулга, сэрэмжлүүлэг өгч, хүсэлт гаргасан 2 иргэний саналыг холбогдох албан тушаалтан, байгууллагад уламжлав. | 70% | |
| 17. | | 18.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Орон нутгийн төсвөөс 2021 онд ГБХЗХХ-ийн үйл ажиллагааны зардалд 282.0 сая төгрөг шийдвэрлэв. Нийслэлийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрт 48.0 сая төгрөг олгосон байна. | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18. | | 18.1.3.Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | ГБХЗХХ нь түр хамгаалах байрыг хэлтсийн дэргэд өөрсдийн нөөц боломжийн хүрээнд 6 ортой 1 өрөөг тохижуулан өндөр эрсдэл бүхий иргэдийг хүлээн авч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Энэ оны хагас жилийн байдлаар гэмт хэргийн хохирогч 1 хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор, Хараа хяналт сул 1 эрэгтэй хүүхэд, хүчирхийлэлд өртсөн 1 эмэгтэй хүүхэд, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 1 эмэгтэй хүүхдийг түр хамгаалах байранд хүлээн авч үйлчилгээ үзүүллээ. Үүнээс эрсдэл өндөр 2 эмэгтэй хүүхдийг ХТҮ-108 төв болон СБД-ийн ГБХЗХХ-ийн нэг цэгийн үйлчилгээний төвд түр шилжүүлэн үйлчилгээ үзүүлж эрсдэл буурсан тул ар гэрт нь эргэн нэгтгэж үйлчилгээг үргэлжлүүлэн хяналтад авч ажиллаж байна. | 70% | |
| | | 19.1.1.Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийллийн сөрөг үр дагаврын талаарх ойлголт өгөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 10 шторк, 35 постерыг орон нутгийн 7 групп, facebook цахим орчинд нийтэлж олон нийтэд түгээлээ. Дүүргийн Цагдаагийн хэлтэс нь гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг гудамж талбайд, олон нийтийн газарт, байгууллагуудын мэдээллийн хэсэгт 4 төрлийн 400 ширхэг мэдээллийг байрлуулсан.<br>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрөөр жендэрт суурилсан хэвшмэл ойлголтыг арилгах чиглэлээр 2 удаагийн нөлөөллийн ажлыг “Яг одоо хүчирхийллийг таслан зогсооё” уриан дор зохион байгуулан олон нийтэд “Багахангай хэвлэл мэдээлэл” цахим хуудас болон дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn вэб сайтаар тус тус хүргэв. Гэр бүлийн харилцаа болон хүчирхийлэлтэй харилцаанаас үүдэх сөрөг үр дагаврын чиглэлээр давхардсан тоогоор биечлэн 15 иргэн, цахимаар 23 иргэнд зөвлөгөө мэдээлэл өглөө.<br>Дүүргийн ГХУСАЗСЗ, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс хамтран гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 21 иргэнийг онлайн хичээлд | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хамруулсан.<br>Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 1 эрэгтэй, 5 эмэгтэйд нөхцөл байдлын үнэлгээ хийж мэргэжилтэнд шилжүүлж, үйлчилгээнд хяналт тавин хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн. Гэр бүлийн хүчирхийллийн 1 тохиолдлыг 2 дугаар хорооны хамтарсан багт шилжүүлэн үйлчилгээнд хяналт тавин ажиллаж байна.<br>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 06 дугаар тогтоол, Засаг даргын 2017 оны А/137 дугаар захирамжаар сар бүрийн сүүлийн долоо хоногийн "Бямба" гарагийг "Гэр бүлийн өдөр" болгон тэмдэглэн өнгөрүүлэх шийдвэр, "Хүүхдэд ээлтэй Багахангай" дэд хөтөлбөрийн хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс сар бүр гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө гарган байгууллага бүр гэр бүл, хүүхдэд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшээд байна. Үүнд: Сургалт нөлөөллийн ажлыг цахимаар 6 удаа, "Миний гэр бүл" сэдэвт гар зураг, "Хүүхдийн эрхийг хамгаалах нь" сэдэвт эссэ бичлэг, "Сэтгэлийн үг" захидал бичих, "Хүүхдийн дууг хэн сайн дуулах вэ" гэр бүлийн дууны тэмцээн, "Ардын бүжгийг хөгжүүлэх нь" гэр бүлийн бүжгийн тэмцээн гэх мэт 12 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд нийт 68 иргэн хамрагдсан байна | | |
| 19. | | 19.1.2.Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд 3 сургалт, 3 хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулсан ба сургалтад давхардсан тоогоор 61 хүн хамрагдаж мэдлэг, ур чадвараа нэмэгдүүллээ. Хамтарсан багийн гишүүдэд кейс үйлчилгээ үзүүлэх, чиглэлээр цахим зөвлөгөө 4 удаа, нөхцөл байдлын үнэлгээ хийх, дүгнэлт бичих чиглэлээр ажлын байран дээр 3 удаа арга зүйн, зөвлөгөө өгч ажиллалаа. | 70% | |
| 20. | | 19.1.3.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулагдаагүй. ГБХЗХХ нь түр хамгаалах байрыг | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | хэлтсийн дэргэд өөрсдийн нөөц боломжийн хүрээнд 6 ортой 1 өрөөг тохижуулан өндөр эрсдэл бүхий иргэдийг хүлээн авч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. | | |
| 21. | | 19.1.4.Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг зохион байгуулах заалтыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>2021 оны эхний хагас жилийн байдлаар дүүргийн ГХУСАЗСЗ-д танилцуулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт зохион байгуулах, сэрэмжлүүлэг тараах зорилгоор 1,350,000 төгрөг шийдвэрлүүлж, төлөвлөсөн ажлаа 100 хувь гүйцэтгэсэн. | 70% | |
| 22. | | 19.1.5.Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Орон нутгийн төсвөөс 2021 онд ГБХЗХХ-ийн үйл ажиллагааны зардалд 282.0 сая төгрөг шийдвэрлэв. Нийслэлийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрт 48.0 сая төгрөг олгосон байна. | 70% | |
| 23. | | 19.1.6.Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг | ЦХ-ийн байранд хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тохижуулж, мэдүүлэг авах өрөөг хяналтын | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: | камерыг байрлуулсан байна. Налайх, Багахангай дүүргийн Прокурорын газраас 2 жилийн хугацаатай "Зөвшөөрөл" авсан. Энэ оны хагас жилийн байдлаар гэмт хэргийн хохирогч 1 хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор, Хараа хяналт сул 1 эрэгтэй хүүхэд, сэтгэл хүчирхийлэлд өртсөн 1 эмэгтэй хүүхэд, үйл хайхрах хүчирхийлэлд өртсөн 1 эмэгтэй хүүхдийн түр хамгаалах байранд хүлээн авч үйлчилгээ үзүүллээ. Нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах талаарх хүсэлтийг дүүргийн ГХУСАЗСЗ-д хүргүүлээд байна. | | |
| 24. | | 19.1.7.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Дүүргийн Цагдаагийн хэлтэс, Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс гэр бүлийн хүчирхийллийн дуудлага бүр дээр хамтран ажиллаж байна.<br><br>Цагдаагийн хэлтэс, иргэн Тунгалагийн хариуцсан "Бид хамтдаа" ТББ хамтран архинаас гаргах зорилгоор архины хамааралтай 5 иргэнийг сайн дурын үндсэн дээр хамруулсан. Мөн "Эр зоригийн хүч" ТББ-тай ГБХЗХХ хамтран үйл ажиллагаа явуулж байна. | 70% | |
| 25. | | 19.1.8.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12.00-16.00, 16.00-20.00 цагуудын хооронд дүүргийн нутаг дэвсгэрт 25 иргэн урамшилтай эргүүлийн үүргийг гүйцэтгэж байна. Мөн хүүхэд хамгаалагч тухай бүр хяналт тавьж байна. | 70% | |
| 26. | | 25.2.Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн | Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2021 оны Б/67 тоот тушаалаар тус цагдаагийн хэлтэст хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог бий болгон, холбогдох албан тушаалтныг томилоод | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно. | байна. | | |
| 27. | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 53.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 4 бүлэг, 13 арга хэмжээтэйгээр боловсруулж батлуулан байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хавсарган хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар "Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөр"-ийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 77,8%-ийн, "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 64,2%-ийн хэрэгжилттэй байна.<br>Нийгмийн салбарын 8 байгууллага нь сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Коронавируст халдварт /covid-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх дархлааг дэмжих зорилгоор витаминжуулах, хамгаалах хэрэгсэл бээлий, амны хаалт олгох зэрэг олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.<br>Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2021 оны А/08 тушаалаар "Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг 2 жилийн хугацаатай боловсруулан баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>ХХҮХ нь төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа 6 зорилт 17 заалт, сургалт ба мэдлэг чадвар бий болгох 3 зорилт 11 арга хэмжээний төлөвлөгөөг 2021.01.25-ны өдөр боловсруулсан бөгөөд 75%-ийн хэрэжилттэй байна. | 70% | |
| Хэсгийн дундаж үнэлгээ: 73.5% | | | | | |
| Улсын их хурлын тогтоол | | | | | |
| 28. | "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх | 3.8.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн | Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд 3 сургалт, 3 хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулсан ба сургалтад давхардсан тоогоор 61 хүн хамрагдаж | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 16 дахь илтгэл"-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах | мэдлэг, ур чадвараа нэмэгдүүллээ. Хамтарсан багийн гишүүдэд кейс үйлчилгээ үзүүлэх, чиглэлээр цахим зөвлөгөө 4 удаа, нөхцөл байдлын үнэлгээ хийх, дүгнэлт бичих чиглэлээр ажлын байран дээр 3 удаа очиж арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. | | |
| Хэсгийн дундаж үнэлгээ: 70% | | | | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| 29. | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/897 дугаар захирамжаар батлагдсан стандартын дагуу дүүргийн 23 байгууллага гадна хаягаа шинэчилсэн байна. ЕБС, СӨБ-ын байгууллагууд гаднах хаягаа монгол бичгээр бичиж байршуулсан байна.<br><br>Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол бичгээр дурсгалын зүйл бичиж өрхийн орлого олдог 1 иргэний төслийг ХХҮХ-ээс дэмжиж 5.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулаад байна. Дүүрэгт зар сурталчилгааны байгууламж байхгүй болно. | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 30. | | 4.Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай. | "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III" үндэсний хөтөлбөрийн холбогдох заалтыг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг уриалан ажиллаж байна. | 30% | |
| Хэсгийн дундаж үнэлгээ: 50% | | | | | |
| Засгийн газрын тогтоол | | | | | |
| 31. | Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258 | 1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай: 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх; | Албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, сарын эцэст хоцролтын бүртгэлийг үндэслэн цагийн балансыг нэгтгэн гаргаж Тамгын газрын даргаар батлуулан цалин урамшууллыг тооцуулан ажиллаж байна. Мөн 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийг /эцэг/ богиносгосон цагаар ажиллуулж байна.<br>ОБЕГ-ын даргын 2021 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг өндөржүүлэх тухай" 03 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх 21 заалт бүхий төлөвлөгөөний дагуу тайланг сард 2 удаа холбогдох дээд байгууллагад хүргүүлж ажиллалаа. Тайлант хугацаанд мэдээ, тайланг 4 удаа хүргүүлж зөрчил дутагдал гаргасан 6 албан хаагчдад цэргийн алба хаагчийн сахилгын шийтгэл ногдуулсан байна. 2021 оны хагас жилийн байдлаар Нийгмийн салбараас 1 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна. | 70% | |
| 32. | | 1.2.иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг | 2021 оны 06-р сарын 14-ний өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан нийт 95 өргөдөл ирснээс ЗДТГ-т 24 /ажилд орохыг хүссэн 10, орон сууц хүссэн 7, тусламж дэмжлэг хүссэн 5/, бусад 2, ХХҮХ-т 31, Татварын хэлтэст 1, Газар зохион байгуулалтын албанд 14, ГБХЗХХ-т 3, ЭМТ-т 18 тус | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх; | тус ирсэн байна. Үүнээс НҮНТ-өөр дамжиж ирсэн 1 гомдол байна. Өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн хариуг 49 иргэнд утсаар, 22 иргэнд цахимаар, 24 иргэнд албан бичгээр өгсөн бөгөөд шийдвэрлэлт 98%-тай байна.<br>Агуулгаар нь авч үзвэл ажилд орох, гэр орон хүссэн, нийгмийн халамж, тусламж дэмжлэг хүссэн өргөдөл 75 хувийг эзэлж байна.<br>Саналын хайрцаг, албаны цахим шуудан, утас, факсаар ирсэн өргөдөл гомдол, санал байхгүй.<br>Онцгой байдлын хэлтэст ирүүлсэн 47 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, эрх хэмжээний хүрээнд 37 өргөдлийг шийдвэрлэж, 10 өргөдлийг холбогдох дээд байгууллагад шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллалаа. | | |
| 33. | | 1.3.төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах; | Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/798 дугаар захирамж, "Төрийн байгууллагуудад ажлын байрны шинжилгээ хийх удирдамж"-ийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/37 дугаар тушаалаар төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, албан хаагчдын ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах санал боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргаар ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, холбогдох заавар, журмын хүрээнд шинжилгээ, судалгаа хийж, тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тогтоосон хугацаанд хүргүүлсэн.<br><br>Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах журам"-д нийцүүлэн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах, ажлын байрны шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулан чиг үүргийн давхардал хийдлийг арилгах зорилгоор ажлын | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байрны шинжилгээ хийх ажлыг 2019 оны 4-5 дугаар саруудад зохион байгуулж, албан тушаалын тодорхойлолтуудыг дахин шинэчлэн боловсруулж, төслийг тайлангийн хамт 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн хянуулж, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 186 дугаар тогтоолоор ЗДТГ-ын даргын, 187 дугаар тогтоолоор ижилтгэсэн нэршил чиг үүрэг бүхий 9 албан хаагчдын, 06 дугаар сарын 23-ны өдрийн 266 дугаар тогтоолоор бусад төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлуулав.<br><br>ОБХ:Байгууллагын үйл ажиллагаанд чанарын нэгдсэн менежментийн тогтолцоог нутагшуулах. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO 45001:2018, нийгмийн хариуцлагын менежмент ISO 26000:2010, Эрсдэлийн менежмент ISO 31000:2010 стандартыг нэвтрүүлж байгаатай холбогдуулан нэгдсэн менежментийн тогтолцооны гарын авлагыг хүлээн авч байгууллагын дотоод үйл ажиллагаанд SWOT шинжилгээ хийж анги, байгууллагын дотоод, гадаад орчноо тодорхойлсон.<br>Ажлын байрны шинжилгээ хийж албан тушаалын ажил үйлчилгээ бүрээр процесс зураглал, ажил үүргийн хуваарь гаргасан.<br>Цагдаагийн хэлтэст төлөвлөлт зохион байгуулалт, дотоод ажил хариуцсан мэргэжилтний орон тоо байхгүй бөгөөд эрүүгийн мөрдөгч, бичээч-архивч нар үндсэн ажил үүрэг дээр хавсран хийж гүйцэтгэж байна. Үүнээс шалтгаалан үндсэн ажлын чанар бүтээмж буурах эрсдэлтэй байгаа бөгөөд орон тоог нэмэгдүүлэх саналыг дээд шатны байгууллагад хүргүүлсэн. | | |
| 34. | | 1.4.төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох | Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах боломжийг бүрдүүлэн удирдлагыг мэдээллээр хангаж, ажлын байрны сул орон тоо гарсан тухай бүр ажлын байрны захиалгыг Төрийн | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх; | албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн, сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд коронавирусын халдварын улмаас бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан 2021 онд төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулагдаагүй, сул орон тоо нөхөх ажил хийгдээгүй байна. | | |
| 35. | | 1.6.төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх; | Тус газарт төрийн жинхэнэ албан хаагчдаас жирэмсний болон амаржсаны амралтаа авсны улмаас 2 ажлын байр эзгүй байна. үүнээс 1 ажлын байранд Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийг үндэслэн түр орлон гүйцэтгэгч томилон ажиллуулж байгаа ба 1 ажлын байрны чиг үүргийг хэлтсийн албан хаагчид албан үүргийнх нь зэрэгцээ хавсруулан гүйцэтгүүлж байна.<br>Коронавирус тархсаны улмаас өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдал зарлаж, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах боломжгүй байгаатай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу тус газрын Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтний ажлын байрны сул орон тоонд гэрээт ажилтан томилон ажиллуулж байна | 70% | |
| 36. | | 1.7.төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн | Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглах талаар тусган ажиллаж байна.<br>2021 онд “Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон болох” “Зам тээврийн зөрчилгүй ажиллах”, “Ажлын байрандаа архидан согтуурахгүй байх”, “Нийгмийн хэв журмын зөрчил дутагдалгүй ажиллах”, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн шторк, | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тохиолдолд хариуцлага тооцох; | санамж зөвлөмжүүдийг фэйсбүүк хуудсанд байршуулан олон хийтэд хүргэн сурталчлах ажлыг зохион байгуулж байна.<br>ХХҮХ нь албан хаагчдыг архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн хэлтсээс Зөрчлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн талаарх сургалтыг 2021.04.26-ны өдөр цахимаар авч сургалтад 15 албан хаагчийг хамруулсан. Тайлангийн хугацаанд ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн албан хаагч байхгүй байна. | | |
| 37. | | 1.8.төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | ЗДТГ-ын тайлангийн хугацаанд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна. Байгууллагын хэмжээнд сахилга хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд сануулах карт олгох ажлыг нэвтрүүлэн ажиллаж байна.<br>Дүүргийн хэмжээнд энэ оны эхний хагас жилийн байдлаар гэмт хэрэгт холбогдсон 1, зөрчлийн тухай хууль зөрчсөн 36 төрийн алба хаагчид арга хэмжээ тооцож, 5 байгууллагын удирдлагад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах талаар “Шаардлага” хүргүүлсэн бөгөөд дүүргийн удирдах ажилтны цахим шуурхай зөвлөгөөнд оролцож, 3 удаа танилцуулсан. Нийгмийн салбараас ТАХ-ийн ёс зүй, харилцаа хандлага сэдэвт сургалтад 9 албан хаагч хамрагдав. | 70% | |
| 38. | | 1.10.ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах; | Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар байгууллагын соёл, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, байгууллагын өрөө тасалгааны өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор "ЭЕРЭГ ХАНДЛАГА-БҮТЭЭЛЧ САНААЧИЛГА" аяныг 2021.05.01-2021.10.31-ний өдрийн хугацаанд зарлан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс алба хаагчдыг сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх үүднээс “Элдэг харилцаа-Эерэг хандлагыг төлөвшүүлэх” аяныг 1 сарын хугацаатай зохион байгуулж байна. | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Ажлын байрын дарамт, шахалт, ялгавартай хандах үйлдлыг таслан зогсоох үүднээс 22 байгууллага байгууллагын дотоод журамдаа тусган хэрэгжүүлж байна.<br>Одоогоор ажлын байрны дарамт шахалт, ялгавартай хандах үйлдэл гараагүй байна. | | |
| 39. | | 3.Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | Албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, сарын эцэст хоцролтын бүртгэлийг үндэслэн цагийн балансыг нэгтгэн гаргаж Тамгын газрын даргаар батлуулан цалин урамшууллыг тооцуулан ажиллаж байна. Мөн 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийг /эцэг/ богиносгосон цагаар ажиллуулж байна.<br>Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улс, нийслэл, дүүргийн Онцгой комисс болон холбогдох дээд шатны байгууллагуудаас ирүүлсэн шийдвэр, зөвлөмж, чиглэлийг дүүргийн Аж ахуйн нэгж, байгууллагуудад тухай бүр хүргүүлж, өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн дэглэм, халдвар хамгаалалтын арга хэмжээг тухай бүр мөрдөж, дүүргийн хэмжээнд болон аж ахуйн нэгж, байгууллагуудын хэмжээнд хариуцлагатай жижүүр томилон байнгын хяналт тавин ажиллаж байна.<br>Онцгой байдлын хэлтэст НОБГ-ын Дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын хэлтсээс төлөвлөгөөт хяналт шалгалтыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулсан.<br>Цагдаагийн хэлтэст дүүргийн аудитын алба, ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтсээс тус тус төлөвлөгөөт бус шалгалтууд ирж шалган, чиглэлийн үйл ажиллагаа бүрэн хангалттай үнэлгээ авсан байна.<br>Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 3 байгууллага дотоод хяналт, дэмжлэгт хяналтыг 5 удаа зохион байгуулсан байна. Уг хяналт шалгалтаар 1 албан хаагч зөрчил гаргасны сануулах сахилгын шийтгэл ногдуулж ажилласан байна. | 70% | |
| Хэсгийн дундаж үнэлгээ: 68.9% | | | | | |
| Нийт дундаж үнэлгээ: 64.3% | | | | | |

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ЭРДЭНЭТУЯА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Х.ЦЭЦЭГСҮРЭН